



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/206/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	15
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. Аудитын санал дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.21 № 1302/89

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Л.СОДНОМ -д

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013020033

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,787.36	109,503.77
33	АВЛАГА	-	3,904.78
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,855.17
335	Бусад авлага	-	49.62
3351	Байгууллагаас авах авлага	-	49.62
34	УРЬДЧИЛГАА	-	2,213.54
34600	Урьдчилж гарсан зардал	-	2,213.54
35	БАРАА МАТЕРИАЛ	99,787.36	103,385.46
354	Хангамжийн материал	99,787.36	103,385.46
35410	Бичиг хэргийн материал	427.98	2,877.48
35420	Аж ахуйн материал	4,714.21	6,548.71
35470	Бусад хангамжийн материал	94,645.17	93,959.27
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	482,198.51	463,177.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	482,198.51	463,177.75
392	Биет хөрөнгө	477,898.51	458,877.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	304,965.05	304,965.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,525.38)	(34,742.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,500.00	69,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,271.11)	(32,041.77)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	180,090.97	221,550.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,500.88)	(70,767.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,104.04	5,104.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,464.18)	(4,690.05)
393	Биет бус хөрөнгө	4,300.00	4,300.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,300.00	4,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	581,985.87	572,681.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	442.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	442.00
413	Өглөг	-	442.00
4136	Бусад өглөг	-	442.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	130.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	-	312.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	581,985.87	572,239.52
51	Засгийн газрын хувь оролцоо	581,985.87	572,239.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	221,691.02	221,691.02
51101	Өмч: - төрийн	221,691.02	221,691.02
512	Хуримтлагдсан үр дүн	191,520.92	181,774.57
51210	Өмнөх үеийн үр дүн	(75,655.04)	184,496.69
51220	Тайлант үеийн үр дүн	267,175.96	(2,722.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	168,773.94	168,773.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	581,985.87	572,681.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,161,454.71	969,575.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	246,987.56	38,829.09
120	Нийтлэг татварын бус орлого	246,987.56	38,829.09
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	25.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25.00	-
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	246,962.56	38,829.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	914,467.14	930,746.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	914,467.14	924,246.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	863,035.90	924,246.50
131005	Хөрөнгийн санхүүжилт	51,431.24	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	6,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	6,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,278.72	972,297.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,278.72	972,297.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,806.61	938,358.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,459.74	664,301.71
210101	Үндсэн цалин	402,038.24	355,358.96
210102	Нэмэгдэл	134,475.67	149,722.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,481.59	61,740.28
210104	Урамшуулал	61,464.25	97,479.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,227.97	89,453.78
210201	Тэтгэврийн даатгал	44,716.20	63,305.49
210202	Тэтгэмжийн даатгал	5,670.00	6,656.90
210203	ҮОМШ өвчний даатгал	4,473.97	5,255.50
210204	Ажилгүйдлын даатгал	1,027.90	1,183.90
210205	Эрүүл мэндийн даатгал	11,339.90	13,051.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,757.13	86,651.60
210301	Гэрэл цахилгаан	2,467.51	2,339.42
210302	Түлш, халаалт	23,388.74	22,769.08
210303	Цэвэр, бохир ус	1,228.89	1,062.34
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	32,672.00	60,480.76
2104	Хангамж, бараа материалын зардал	25,930.47	20,764.13
210401	Бичиг хэрэг	3,840.61	6,166.90
210402	Тээвэр, шатахуун	6,460.45	3,368.19
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,276.99	3,410.04
210404	Ном, хэвлэл	156.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	313.30	1,056.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,883.12	6,762.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,900.00	9,016.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	1,000.00
210604	Урсгал засвар	13,900.00	8,016.00
2107	Томилолт, зочны зардал	2,593.20	6,606.90
210702	Дотоод албан томилолт	2,593.20	6,606.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,474.70	58,404.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	29,362.00	56,233.82

үйлчилгээний төлбөр хураамж			
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	540.00
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50.70	48.49
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,060.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,463.40	3,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	161.00	-
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	6,302.40	3,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,472.11	33,939.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,083.40	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,058.40	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	25.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,155.70	33,843.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,735.70	30,243.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,233.01	95.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,233.01	95.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	267,175.98	(2,722.12)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	267,175.98	(2,722.12)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	221,691.02	168,773.94	(75,655.06)	314,809.89
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,691.02	168,773.94	(75,655.06)	314,809.89
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	267,175.98	267,175.98
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	221,691.02	168,773.94	191,520.92	581,985.87
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	221,691.02	168,773.94	191,520.92	581,985.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,691.02	168,773.94	191,520.92	581,985.87
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,722.12)	(2,722.12)
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	221,691.02	168,773.94	181,774.57	572,239.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	863,060.90	930,746.50
110003	Хөрөнгийн орлого	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	25.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	863,035.90	930,746.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	863,035.90	924,246.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	863,035.90	924,246.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	6,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн	-	6,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	863,060.90	930,496.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	863,060.90	930,496.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,588.79	899,007.25
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	615,459.74	675,688.50
210101	Үндсэн цалин	402,538.24	364,146.24
210102	Нэмэгдэл	134,475.67	149,722.56
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	17,481.59	62,019.78
210104	Урамшуулал	60,964.25	99,799.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,227.97	91,004.00
210201	Тэтгэврийн даатгал	44,716.20	63,976.40
210202	Тэтгэмжийн даатгал	5,670.00	6,756.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,473.97	5,405.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,027.90	1,351.40
210205	Эрүүл мэндийн даатгал	11,339.90	13,513.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,085.14	26,170.84
210301	Гэрэл, цахилгаан	2,467.51	2,339.42
210302	Түлш, халаалт	23,388.74	22,769.08
210303	Цэвэр, бохир ус	1,228.89	1,062.34
2104	Хангамж, бараа материалын зардал	18,262.64	26,850.00
210401	Бичиг хэрэг	3,300.20	8,693.40
210402	Тээвэр, шатахуун	6,333.00	5,581.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,276.99	3,047.38
210404	Ном, хэвлэл	156.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	423.10	1,056.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,773.35	8,471.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,420.00	9,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,000.00
210604	Урсгал засвар	13,420.00	8,010.00
2107	Томилолт, зочны зардал	2,593.20	6,606.90
210702	Дотоод албан томилолт	2,593.20	6,606.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,474.70	60,517.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,362.00	54,656.52
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	540.00
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50.70	48.49
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,065.40	3,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,960.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,105.40	3,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,472.11	31,489.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,058.40	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,058.40	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,155.70	31,393.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,150.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,735.70	30,243.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,258.01	95.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,258.01	95.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	250.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	250.00
223001	Бусад хөрөнгө	-	250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(250.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	924,246.50	924,150.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924,246.50	924,150.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	892,853.10	892,757.25
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	675,688.50	675,688.50
210101	Үндсэн цалин	389,404.90	364,146.24
210102	Нэмэгдэл	119,496.30	149,722.56
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	62,832.00	62,019.78
210104	Урамшуулал	103,955.30	99,799.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,004.00	91,004.00
210201	Тэтгэврийн даатгал	63,976.40	63,976.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,756.90	6,756.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,405.50	5,405.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,351.40	1,351.40
210205	Эрүүл мэндийн даатгал	13,513.80	13,513.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,171.50	26,170.84
210301	Гэрэл, цахилгаан	2,541.20	2,339.42
210302	Түлш, халаалт	22,348.50	22,769.08
210303	Цэвэр, бохир ус	1,281.80	1,062.34
2104	Хангамж, бараа материалын зардал	26,850.00	26,850.00
210401	Бичиг хэрэг	8,693.40	8,693.40
210402	Тээвэр, шатахуун	5,672.00	5,581.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,957.10	3,047.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,056.50	1,056.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,471.00	8,471.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,510.00	2,510.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000.00	1,000.00
210604	Урсгал засвар	1,510.00	1,510.00
2107	Томилолт, зочны зардал	6,692.00	6,606.90
210702	Дотоод албан томилолт	6,692.00	6,606.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,777.10	60,767.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,664.40	54,656.52
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	540.00
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50.70	48.49
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000.00	5,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,160.00	3,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	3,160.00	3,160.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,393.40	31,393.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,393.40	31,393.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,150.00	1,150.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,243.40	30,243.40
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	924,246.50	924,246.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	924,246.50	924,246.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	924,246.50	924,246.50

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөг/ Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500.00
210604	Урсгал засвар	6,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(6,500.00)

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн Татварын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 20-ны өдрийн №21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн татварын хэлтэс нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дээд байгууллагаас гаргасан системийн хэмжээнд дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэдэг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулан мөрддөг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглаж, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Татварын хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 872.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	3,904.78	3,904.78
Урьдчилгаа	-	2,213.54	2,213.54
Бараа материал	99,787.36	103,385.46	3,598.09
Үндсэн хөрөнгө	482,198.51	463,177.75	(19,020.76)
Нийт хөрөнгө	581,985.87	572,681.52	(9,304.35)
Өр төлбөр	-	442.00	442.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	581,985.87	572,239.52	(9,746.35)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	581,985.87	572,681.52	(9,304.35)

Авлага дансны үлдэгдэл 3.9 сая төгрөгөөр өссөн нь аудитын явцад залруулагдсан ажиллагсадтай холбоотой авлага 3.85 сая төгрөгөөр, бусад байгууллагаас авах авлага 0.05 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2.2 сая төгрөгөөр өссөн нь шатахууны карт цэнэглэлттэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.6 сая төгрөгөөр өссөн нь дээд байгууллагаас үнэ төлбөргүй шилжин ирсэн 20.5 сая төгрөгийн дүрэмт хувцас, худалдан авсан 25.7 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 19.7 сая төгрөгийн бараа материал зарцуулагдаж, 22.9 сая төгрөгийн хангамжийн материалыг шилжүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19.0 сая төгрөгөөр буурсан нь 0.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 41.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж шилжин ирсэн, 60.5 сая төгрөгийн элэгдлийн зардал хасагдсан зэрэгтэй холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр өссөн нь татвар, НДШ-ийн өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 924.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 924.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 924.2 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа, ажил үйлчилгээний зардалд 892.8 сая төгрөгийг зарцуулж, 31.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр засаг даргын нөөц сангаас 6.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, сэлбэг, урсгал засварын зардалд 6.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Завсрын аудитаар 22.3 сая төгрөгийн зардлын и баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчлийг залруулах зөвлөмж хүргүүлсэн. Жилийн эцсийн тайлан баталгаажуулах аудитаар энэ зөвлөмж 100 хувийн хэрэгжсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Авлага, өглөгийн бүртгэлийг үнэн зөв тайлагнаагүй алдааг аудитын явцад залруулсан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 4 мэдээ хугацаа хоцроож, цалингаас бусад 5 саяас дээш үнийн дүнтэй мэдээг буруу мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан журамд Land Cruiser Prado J150 /Хөдөлгүүрийн багтаамж-2700/ авто машины 100км-т зарцуулах шатахууны норм 11.4 л байна гэж заасан байхад жолоочийн тооцоог 18-20 л гэсэн нормоор хийж байна. Шалгагдагч байгууллага автомашины мотор муу, насжилт ихтэйгээс шатахууныг нормоос илүү зарцуулдаг гэсэн тайлбар өгсөн. Завсрын аудитаар шатахууны бодит хэрэглээг комисс гарган тогтоох зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул дараагийн аудитаар энэ асуудлыг авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсрын үеийн аудитад 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлан хамрагдсан бөгөөд 34.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлснээс 23.7 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 13.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн залруулсан.

4.2.1 Залруулсан алдаа

1.1. Илрүүлэлт:

- ✓ Урьд оны тайланд тусгаагүй 7.0 сая төгрөгийн татварын өглөгийг завсрын аудитаар залруулга хийх зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлээгүй, тайлант оны цалингийн зардлаар бүртгэсэн;
- ✓ Завсрын аудитаар ажилтнуудад 3.6 сая төгрөгийн цалин илүү тооцож олгосон зөрчлийг авлагаар тусгах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлээгүй;
- ✓ Шатахууны картад 2.2 сая төгрөгийн урьдчилан шилжүүлсэн мөнгөн төлбөрийг бараа материалаар бүртгэсэн;
- ✓ Ажилчдад олгосон түлээ нүүрсний хөнгөлөлтөөс 0.16 сая төгрөгийн НДШ зардал, 0.28 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй олгосон;

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд 6.1 сая төгрөгийн, үр дүнгийн тайланд 7.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн

4.2.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.2.3 Албан шаардлага хүргүүлээгүй.

4.2.4 Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Татварын хэлтэс	5	13.3	5	13.3						
	Дүн	5	13.3	5	13.3						